

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

2023 оны 02 сарын 27

Дугаар 02

Зуунмод

“АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

“Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцын тайланд хяналт-шинжилгээ хийж үнэлэх, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн түвшингээр тодорхойлж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үнэлгээ, дүгнэлт гаргах

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2022 оны 300 дугаар захирамжаар батлагдсан “бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ирүүлсэн тайлан мэдээ, холбогдох нотлох баримтад тулгуурлан гүйцэтгэлд үнэлгээ өгөх

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг зохион байгуулах

Гурав. “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тухайд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 8 зорилтын 254 арга хэмжээний дундаж үнэлгээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 87.86 хувьтай хэрэгжсэн бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 91.81 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдэж өмнөх үеэс 3.95 пунктээр өссөн байна.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хүний хөгжлийн бодлогын 18 зорилт 67 арга хэмжээний дундаж үнэлгээ 92.15 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Боловсролын салбарт 2021-2022 онд 26,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах ажил арга хэмжээг хийж хэрэгжүүлжээ. Үүнд:

- Дэлгэрхаан сумын 160 хүүхдийн бага сургуулийн өргөтгөл, Батсүмбэр суманд 920 хүүхдийн сургууль,
- Баянхангай, Архуст, Мөнгөнморьт сумдад 165 хүүхдийн дотуур байр,
- Эрдэнэсант суманд 100 хүүхдийн цэцэрлэг, Баянжаргалан, Баян, Алтанбулаг, Эрдэнэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг барьж ашиглалтад оруулж,
- Баянчандмань, Жаргалант, Баяндэлгэр, Баянцогт, Зуунмод, Аргалант, Эрдэнэсант сумдын сургууль Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг болон Дэлгэрхаан, Борнуур сумын цэцэрлэгийн засварын ажлууд бүрэн хийгджээ.

14 Сургалтын байгууллага орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болж, сургалтын таатай орчинг үе шаттай бүрдүүлснээр суурь боловсролын хамран сургалт 90.6 хувьд хүрчээ.

2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 506.8-д хүрсэн байна.

2021-2022 онд эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, Баян-өнжүүл, Өндөрширээт, Баянцогт сумдад шинээр эрүүл мэндийн төв барьж, 6 барилгыг өргөтгөл, засварт хамруулж, түргэн тусламжийн автомашин 25-ыг нийлүүлж тусламж үйлчилгээний чанар, яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдан, иргэдэд тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх ээлтэй орчин бүрдүүлсэн байна.

Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн техник, технологийг өргөжүүлж, иргэд орон нутагтаа оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлж, нийт 12,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 192 төрлийн 668 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлж, тоног төхөөрөмжийн стандарт хангалт:

- Нэгдсэн эмнэлэгт 83 хувь,
- Сумын эрүүл мэндийн төвүүдэд 63.7 хувь,
- Өрхийн эрүүл мэндийн төвд 75 хувьд хүрч, суурь түвшнээс 6.5-12.7 пунктээр өссөн байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт оношилгооны төв буюу “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулан 7 төрлийн дурангийн оношилгоо, эмчилгээний аппарат, бөөрний диализ, хавдрын хими эмчилгээ, тархины судасны бичлэг, чих хамар хоолойн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, иргэд орон нутагтаа өндөр өртөгтэй, эмчилгээ, оношилгоо хийлгэх боломж бүрдэж, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж үйлчилгээтэй адил түвшинд хүрчээ.

Гэр бүлийн андгай өргөх, гэрчилгээ гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж, 21 сумын 186 хосын гэрлэлтийг батлуулан, энэ нь гэр бүлийн үнэ цэнэ, хариуцлагыг ойлгуулсан үр дүнтэй арга хэмжээ болж байна.

Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Төв аймгаас төрж гарсан “Эрдэмтдийн нэгдсэн судалгааны сан” бүрдүүллээ.

2021-2022 онд нийт эрдэмтэн судлаачидтай хамтран “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө”, “Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө”, “Цардуулын үйлдвэр” буюу шахмал түлшний барьцалдуулагч түүхий эд үйлдвэрлэх төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт, “Хоршооны үйл ажиллагаанд гэрээт менежментийг нэвтрүүлэх” зэрэг 8 судалгааны ажлыг хийжээ.

“Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын 3 зорилт 8 арга хэмжээний хэрэгжилт 98.75 хувтай “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хүрээнд аймгийн Музейн сан хөмрөгийг 34 дэсийн 53 ширхэг үзмэрээр баяжуулж, музейн 5680 үзмэртэй болж, аймгийн Монгол туургатан театр

- “Монгол туургатан” бүрэн хэмжээний дэлгэцийн контент 1,
- “Аргалын утаат нутаг” олон ангит уран сайхны кино 1,
- Хүүхдийн жүжиг 2 шинээр найруулан тавьж,
- “Учиртай гурван толгой”, “Ламбугайн нулимс” дуурь,

- “Шар гэгээ” драмын жүжгийг шинээр болон сэргээн найруулж нийт 7 уран бүтээл, 8 контент туурвиж, 42687 гаруй үзэгчдийн хүртээл болгожээ.

Тайлант хугацаанд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулан, 27 сумын 432 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамруулж, төвийн бүсийн соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалтыг зохион байгуулж, 11 сумын 60 өвлөн уламжлагчийг бүртгэлжүүлсэн байна.

Аймгийн нийтийн номын санг хүний хөгжлийн мэдээллийн төвийг болгон өргөжүүлжээ.

Хүүхэд багачуудыг амьдрах ухаанд сургах хөдөлмөрт бэлтгэх “Хүүхдийн хөдөлмөр зуслан”-г Баянчандмань, Жаргалант, Мөнгөнморьт, Эрдэнэсант сумд байгуулахад орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж, үндэсний өв соёл, зан заншлаа дээдэлсэн бүтээлч Монгол хүнийг хөгжүүлэхэд нөлөөлөл үзүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

“Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая-2025” аян өрнүүлж, “Монгол бичигтэн байгууллага”, “Үндэсний бичгээ дэлгэрүүлэгч багш”, “Монгол бичгийн цахим бичвэр-2022” уралдааныг зохион байгуулж, 6-12 ангийн 286 бүлгийн 7150 сурагч оролцож, үндэсний бичгийн хэрэглээ үе шаттайгаар нэмэгдэж байна.

Монгол бичгийн сургалтад 2747 төрийн албан хаагч буюу нийт төрийн албан хаагчийн 48,7 хувь хамрагдсан нь суурь түвшнээс 28.9 пунктээр өссөн байна.

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Эдийн засгийн бодлогын 2 зорилт 13 арга хэмжээний дундаж үнэлгээ 100 хувьтай буюу “Үр дүнтэй” байна.

Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж сайн дурын даатгалд 6876 даатгуулагчийг хамруулж, 2946.4 сая төгрөгийг санд төвлөрүүлсэн нь суурь түвшнээс хамралт 292 даатгуулагчаар, орлого 1638.3 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Нийгмийн халамжийн 16 бүлгийн 69 нэр төрлийн үйлчилгээг “Халамжийн нэгдсэн систем-Ehalamj”-д нэвтрүүлж нийт 74866 иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийг олгосон байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх сургалтад 2495 иргэнийг хамруулж, Эрдэнэ, Заамар сумдын МСҮТ-тэй хамтран 4 мэргэжлээр 183 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж, бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд нийт 2032 шинэ ажлын байр бий болсон байна.

Аймгийн ядуурлын түвшин 19.3 хувь болж өмнөх оноос 1.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зорилтот бүлгийн болон төрийн байгууллагад ажилладаг өрхийг орон сууцаар хангах зорилгоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 05 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцны журам”-ыг батлуулан хэрэгжүүлж “Түрээсийн орон сууц”-ны санг 2 эх үүсвэрээр бүрдүүлж байна.

Дэд бүтэц нь шийдэгдсэн газар орон сууц барьсан аж ахуйн нэгжээс баригдсан орон сууцны нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлж 2019 оноос хойш 6 аж ахуйн нэгжээс 216.1 м² бүхий 6 орон сууц авч, цаашид 525.6 м² бүхий 14 орон сууц авахаар гэрээ хэлцэл хийгдсэн байна.

Орон нутгийн төсөвт 2020 онд 400.0 сая, 2021 онд 400.0 сая, 2022 онд 800.0 сая төгрөг тусган 1159 м² бүхий 22 орон сууц авсан ба дээрх 2 эх үүсвэрээс одоогийн байдлаар 1375.1 м² талбай бүхий 1-2 өрөө 28 айлын түрээсийн орон сууцтай болжээ.

2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Бүтэц” компаниас 10, “Төв цогт өлзийт” компаниас 40 орон сууц нийт 50 орон сууц авах бөгөөд нийтдээ 64 орон сууцаар түрээсийн орон сууцны сан нэмэгдэж өссөн дүнгээр 92 түрээсийн орон сууцтай болох нөхцөл бүрдээд байна.

Журмын дагуу орон сууцны түрээсээр 2020 онд 42,7 сая төгрөг, 2021 онд 46,6 сая төгрөг, 2022 онд 50,7 сая төгрөг, нийт 153,9 сая төгрөгийг орон сууцны санд төвлөрүүлээ.

2021-2022 онд өссөн дүнгээр 74940 иргэнд 13820.18 га газар өмчлүүлж газар өмчлөлийн явц 79 хувьд хүрсэн бөгөөд 5 жилийн үндсэн чиглэлд дэвшүүлсэн 73.1 хувьд хүргэх зорилт 108.0 хувьтай амжилттай хэрэгжиж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хөдөө аж ахуйн бодлогын 3 зорилт 37 арга хэмжээний дундаж үнэлгээ 92.89 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өрнүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд “хөгжлийн түүчээ-Төв аймаг эдийн засгийн чуулганыг 2022 онд зохион байгуулж, 814,1 тэрбум төгрөгийн, 3000 гаруй ажлын байр бий болгох хамтын ажиллагааны гэрээ байгуулан

- “Цардуулын үйлдвэр”,
- “Зуунмод үйлдвэр технологийн парк”,
- “Мах боловсруулах үйлдвэр”,
- “Махны ферм”,
- “Сүүний кластер ферм”,
- “Мах бэлтгэлийн хоршоо”,
- “Сүү бэлтгэлийн хоршоо” төслүүд амжилттай хэрэгжиж, 29,4 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Аж үйлдвэрийн салбарт 2022 оны байдлаар 186.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 68.7 хувь буюу 75,8 тэрбум төгрөгөөр, тусгай сангууд болон болон “Эдийн засгийн сэргээх хөтөлбөр”-ийн хөнгөлөлттэй зээлд нийт 982 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, 23,6 тэрбум төгрөгийн зээл олгож, 2 үйлдвэр, 47 цех шинээр байгуулагдсанаар боловсруулах салбарын үйлдвэрлэл 17.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.5 дахин буюу 12,5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 онд 851,2 тэрбум төгрөгт хүрч 2020 оноос (703,8) 17.3 хувиар өсч эдийн засгийн дундаж өсөлтийг 6-10 хувьд хүргэх зорилт амжилттай хэрэгжиж, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 719,4 тэрбум төгрөгт хүрчээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн орлогод 5,2 тэрбум төгрөг, аймгийн төсвийн орлогод 9,5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн орлогод 37,0 тэрбум төгрөг нийт 51,7 тэрбум төгрөг төвлөрүүлж, 3 шатны татварын орлогын төлөвлөгөөг 127.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар төсвийн зарлагад 78,8 тэрбум төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 69,3 тэрбум төгрөг зарцуулж, 9,6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс хэмнэлттэй зарцууллаа.

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн, төсөвт тодорхой хэмжээний хэмнэлт бий болсноор төсвийн шилжих үлдэгдлийн жилийн эцсийн мөнгөн дүн 6,1 тэрбум төгрөгөөр давжээ. Энэ хэмжээгээр цар тахлын улмаас учирсан санхүү, эдийн засгийн хүндрэлүүдийг даван туулах, төрөлх аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтсан бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтууд хийгдэх боломж бүрджээ.

НОГООН ХӨГЖИЛ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ногоон хөгжлийн бодлогын 5 зорилт, 39 арга хэмжээний хэрэгжилт 91.44 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хүрээнд 2030 он хүртэл 20.0 сая модыг ургуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд 840,4 мянга, 2022 онд 1,1 сая, 2021-2022 онд нийт 2,0 сая мод бут сөөг тарьж ургуулжээ.

Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг 2021 онд 24,6 га, 2022 онд 92,8 га талбайгаар буюу ногоон байгууламжийн хэмжээг 81.7 хувиар нэмэгдүүлж, аж ахуйн нэгж байгууллага, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6 суманд нийт 208,5 га талбайд, өссөн дүнгээр 1819 га талбайд ойжуулалт хийжээ.

2021 онд бэлчээрийн зориулалттай 35 худаг, 2022 онд 33 худаг гаргаж, бэлчээр усжуулалт 76.1 хувьд хүрсэн байна.

Хог хаягдлын төвлөрсөн цэгийн зэрэглэлийг ахиулж, хашаа хамгаалалт, түрж булшлах талбайн ашиглалтыг сайжруулж түрэлт, багасгалтыг 8 сум нийт 27,5 га талбайд зохион байгуулж, аймгийн хэмжээнд I зэрэглэлийн шаардлага хангасан 16 төвлөрсөн хогийн цэгтэй болж үндсэн чиглэлийн зорилтыг 133.3 хувьтай биелүүлжээ.

Аймгийн хэмжээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг 2020 оноос эхлэн үе шаттайгаар зохион байгуулж, 2021 онд 12, 2022 онд 15 сумын 667 усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийг 172406 га, энгийн хамгаалалтын бүсийг 262294 га талбайгаар зураглан усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох ажил бүрэн хийгдсэн байна.

Ард иргэдийг эрүүл, аюулгүй, стандартад нийцсэн усаар хангах зорилгоор ундны усны худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж 2022 онд Алтанбулаг, Батсүмбэр, Жаргалант, Баян-Өнжүүл сумын худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулж аймгийн хэмжээнд 27 сумын 44 худагт ус зөөлрүүлэх, цэвэршүүлэх төхөөрөмжтэй болсон байна. Мөн 27 сумын хэмжээнд 64 ундны усны худагт ус түгээх цахим төхөөрөмжтэй ажиллаж байна.

Эвдрэлд орж нөхөн сэргээлгүй орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийх ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн жилийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж 2022 оны байдлаар өссөн дүнгээр 319,19 га талбайд техникийн, 277,06 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

“Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г батлуулж 2022 онд “Аймгийн аялал жуулчлалын салбарын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, “Төв түмний цэнгэл-2022” наадмын эвент, “Хонины найр” арга хэмжээ, “Шинэ оны анхны нар харах аялал”-ыг зохион байгуулж 45000 гадаадын жуулчид, 55000 дотоодын аялагчид амралтын газар, гэр буудлаар үйлчлүүлсэн байна.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Бүс, орон нутгийн хөгжлийн 9 зорилт, 56 арга хэмжээний зорилт 84.08 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Аймгийн нутаг дэвсгэрт үндэсний шинэ бүтээн байгуулалт болох “Эдийн засгийн чөлөөт бүс”, “Богд хан төмөр зам”, “Шинэ хот”-уудыг байгуулах ажлууд эхэлж, Хөшгийн хөндийд өрнөх шинэ бүтээн байгуулалттай Зуунмод хотын хөгжлийг уялдуулан, зэрэгцэн хөгжих боломжийг бүрдүүлэх, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, орон нутагт баялаг бүтээх нөхцлийг бүрдүүлж, хөгжлийг тэтгэсэн дэд бүтцийг бий болгох, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах ажлыг эхлүүлжээ.

Хөгжлийг тэтгэсэн дэд бүтцийн ажлын хүрээнд 5,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4000м³ усан сан, усан хангамжийн шугам сүлжээ, I, III өргөх станцын барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажил бүрэн дуусаж, 18,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий цахилгаан хангамжийн 110 киловольтын дэд станц, шугам сүлжээ, 48,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 мегаваттын дулааны станц, 11,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий дулааны станцын II хэлхээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдэж нийтдээ 84,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий суурь дэд бүтцийн ажлууд эхлээд байна.

Хүн амын суурьшлыг бий болгох зорилгоор II ээлжийн 2000, III ээлжийн 1500 нийт 3500 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийг хийж, дэд бүтэц, барилгажилтын ажил эхэлж байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөлд 14 сум, 3 багийн төв хамрагдаж энэ онд Борнуур, Эрдэнэ, Баянчандмань, Сэргэлэн, Дэлгэрхаан зэрэг 5 сумын 15,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил эхэлжээ.

Угтаалцайд, Цээл, Заамар, Аргалант сумын авто замын барилгын 124,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил эхэлж 16 сум улсын чанартай авто замтай хатуу хучилттай авто замаар холбогдох нөхцөл бүрдэж 130,4 км авто зам шинээр ашиглалтад орох нөхцөл бүрджээ.

Аймгийн “Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө”-г боловсруулан, археологийн музей байгуулах ажил хийгдэж, нисэх онгоцны буудал-зуунмод хотыг холбосон 8,4 км авто зам, Манзушир-Зуунмод чиглэлийн 7,4 км авто замыг ашиглалтад оруулсан байна.

Цар тахлын улмаас удааширсан улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хийж буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг хугацаанд нь ашиглалтад оруулах, барилга царцааж, хөрөнгө татуулахгүй байх зорилгоор улс, аймаг, төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 78,7 тэрбум, 2022 онд 139,0 тэрбум, нийт 217,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 2 сургууль, 5 дотуур байр, 6 цэцэрлэг, 3 соёл спортын төв, 3 эрүүл мэндийн төв зэрэг 19 барилга ашиглалтад оруулж, 16 барилга он дамжин баригдаж байна.

Сумын төвийн гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох төслийг эхлүүлж 2021-2022 онд 18 суманд төсөл хэрэгжиж 11 аж ахуйн нэгж, 178 айл өрх, сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах төсөл хэрэгжүүлж 18 сум хамрагдаад байна.

Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийг 2022 оноос хэрэгжүүлж 7 суманд 18 айлын орон сууц баригдсан байна.

Монгол Улсын Засгийн газраас шинэ сэргэлтийн бодлогыг эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлын суурь баталгаа хэмээн үзэж дотооддоо хүнсээ хангаж,

“Түүхий эд нийлүүлэгч улсаас Аж үйлдвэржсэн улс болох”, нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулах зорилт дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг санаачлан эхлүүлжээ.

Аймгийн эдийн засгийн үндсэн салбар болсон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг хангах зорилгоор “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт” болон 24 төслийг боловсруулан хэрэгжүүлж, сумдад анхан шатны болон дундын хоршоодыг байгуулж, үндэсний болон орон нутгийн үйлдвэрүүд, олон улсын байгууллагатай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлжээ.

Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 1,0 тэрбум төгрөгт хүргэн, эх үүсвэрийн тодорхой хувийг хоршоодод зээл олгох бодлогыг хэрэгжүүлж, 2021 онд 10 хоршоонд 315,0 сая төгрөг, 2022 онд 38 хоршоонд 939,0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн “Хоршооны үйл ажиллагаанд гэрээт менежментийг нэвтрүүлэх нь” сэдэвт Монгол Японы хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулж 2021-2022 онд 3 үйлдвэр, 47 цех, 187 анхан шатны хоршоо, 8 дундын хоршоо шинээр байгуулагдсан байна.

Аймгийн “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт”-ийн хүрээнд боловсруулагдсан төслүүдээс “Эрчимжсэн үхрийн аж ахуй” төсөл Баяндэлгэр, Аргалант, Сэргэлэн суманд байгуулагджээ.

Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үхэр сүргийг “Сэлэнгэ”, герефорд үүлдрээр, хонин сүргийг барга, үзэмчин үүлдрээр сайжруулагчаар нийлүүлэх ажлыг зохион байгуулж, 22 суманд 484 өсвөр хуцыг сайжруулагчаар нийлүүлсэн байна.

2021-2022 онд зохиомол хээлтүүлэгт хамрагдсан үнээний тоо 4477, хонины тоо 2800 болж өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны эцэст цөм сүргийн малын тоо 586,8 мянган толгойд хүрч, нийт сүрэгт эзлэх хувь 11.7 хувь, цэвэр эрлийз малын тоо 325,7 мянган толгойд хүрч нийт сүрэгт 11.3 хувийг эзэлж байна.

Мөн “Бэлчээрийн мал аж ахуйн үр өгөөжийг дээшлүүлж, өсвөр малыг эдийн засгийн эргэлтэд оруулах мал мах, сүү бэлтгэлийн тогтолцоо бий болгох”, “Сүү, мах, хүнсний ногоо, таримал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төслүүдийг сумдад хоршоодоор дамжуулан амжилттай хэрэгжүүлж 2022 оны эцэст аймгийн хэмжээнд 5,1 сая толгой мал тоологдож малын тоо толгойгоор улсдаа гуравдугаар, эрчимжсэн аж ахуйгаар улсдаа тэргүүн байранд эрэмбэлэгдсэн байна.

Үхэр сүргийн тоо болон эрчимжсэн үхрийн тоо өссөнөөр жилдээ 100,0 сая литр сүү нийлүүлж байна. 2022 онд “Төв түмний сүүн соёл-Сүүний баяр” арга хэмжээг аймгийн хэмжээнд анх удаа зохион байгуулжээ.

Аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлд 2021 онд 435,8 мянган тн ургац хураан авч нийт хураан авсан ургацаараа улсдаа тэргүүлж, 2022 онд 307,5 мянган тн ургац хураан авчээ.

Газар тариалангийн үйлдвэрлэлд 2021 онд 214,9 мян.га, 2022 онд 193,6 мян.га талбай ашиглаж, талбайн ашиглалт 2021 онд 71.8 хувь, 2022 онд 64.7 хувьд хүрсэн байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд 3920 га-д усалгаатай тариалан эрхэлж усалгаатай талбайн хэмжээ өнгөрсөн жилээс 320-га-аар нэмэгдэж 8,8 хувиар өссөн байна. Усалгаатай тариалангийн талбайг 3778 га талбайд хүргэх зорилт 87.0 хувьтай хэрэгжиж байна.

2022 онд үр үржүүлгийн эрхтэй 4 аж ахуйн нэгж улаан буудай 1250 га, хошуу будаа 260 га, арвай 100 га-д тариалалт хийж, буудайн 1150 тн, хошуу будааны 500 тн, арвайны 100 тн, нийт 1750 тонн үр үржүүлж

2022 оны ургацаас:

- Үр тарианы 8720 тн,
- Арвай, овъёос, хөх тарианы 2130 тн үр,
- Төмсний үр 30 мян.тн-г нөөцөлж үндсэн чиглэлийн үр үйлдвэрлэх зорилт 145.3 хувьтай хангагдсан байна.

ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Засаглалын бодлогын 11 зорилт, 51 арга хэмжээний дундаж үнэлгээ 95.16 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

2021-2022 онд аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв 435294 иргэнд үйлчилгээ үзүүлж, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн систем (e-mongolia)-ээр дамжуулан 18 байгууллагын 190 төрлийн нэг болон олон шатлалт 19250 үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Иргэд, аж ахуйн нэгжээ сонсдог үйл ажиллагааг өргөжүүлж, “Иргэдтэй уулзах цаг”-ийг 2022 оны 04 дүгээр сараас эхлэн 6 удаа зохион байгуулж, 169 иргэний 253 санал, хүсэлт, гомдол, талархлыг хүлээн авч шийдвэрлэжээ.

Аймгийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан” (www.tov.unelgee.gov.mn)-д 14 шинэ цэсийг нэмж баяжилт хийж, цаасан суурьт тайланг цахим хэлбэрт шилжүүлсний үр дүнд цаасны хэрэглээг 90 хүртэлх хувиар бууруулжээ. Мөн Эрдэнэ, Эрдэнэсант, Дэлгэрхаан сумдад “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний цахим сан” (www.plan.igovernment.mn)-г нэвтрүүлж, дараагийн 24 сумдад нэвтрүүлэхээр 2023 оны орон нутгийн төсөвт 62,5 сая төгрөг тусгасан байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд “Чанарын менежментийн тогтолцоо” олон улсын стандарт нэвтрүүлж, үйлчилгээний чанарт ахиц гарган ажиллах зорилтын хүрээнд Зуунмод, Эрдэнэ сум болон аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын хэлтэс болон Нэгдсэн эмнэлэг MNS ISO-9001:2015 стандартыг нэвтрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтийг хангаж бүртгэлийн системийг шинэчилж 27 суманд иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээ, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант, Эрдэнэсант суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэвтрүүлснээр 113,9 мянган иргэнд төрийн үйлчилгээг цахимаар үзүүлжээ.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд 22880 иргэнд буюу нийт хүн амын 35.1 хувьд тоон гарын үсэг олгосноор улсын хэмжээнд тэргүүлсэн байна.

Авилгатай тэмцэх газрын шударга байдлын үнэлгээгээр 2022 онд 81.6 хувьтай дүгнүүлж 21 аймгаас 1 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.

Орон нутгийн хууль сахиулах байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж улс, орон нутгийн төсвөөс 1631.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд:

- Нэг цэгийн үйлчилгээ бүхий 73 хүний багтаамжтай төв цагдан хорих байрны барилгын ажил эхэлсэн

- Төв аймаг дахь Цагдаагийн газрын барилгын зураг төсөв хийгдсэн
- Шүүхийн шинжилгээний албаны гистологийн лаборатори барих газрыг шийдвэрлэж, техникийн нөхцөл, зураг төсвийн тооцоолол гаргасан
- Аймгийн нутгийн удирдлагын байгууллагаас хууль сахиулах байгууллагуудын автопарк шинэчлэлийг хийж 18 автомашинаар хангасан байна.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгсэл, алба хаагчийн нэг бүрийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж, гудамж талбай, дотоод орчны камержуулалтыг шийдвэрлэжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд 2020 онд 735, 2021 онд 611, 2022 онд 754 гэмт хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн илрүүлэлт 64.3 хувьд хүрч, улсын дунджаас 9.1 пунктээр дээгүүр байна.

Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 82.0 хувьд хүрч, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад гэмт хэргийн илрүүлэлтээрээ хамгийн өндөр үзүүлэлт гаргаж, улсын дунджаас 21.7 хувиар өсч, улсын хэмжээнд 1 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, цаашид анхаарах асуудлууд:

1. Жирэмсний эрт үеийн хяналт 92.8 хувьд хүрч, улсын дунджаас 1.3 пунктээр дээгүүр байна. Перинаталь эндэгдлийн түвшин 5.4 промилээр суурь түвшнээс буурсан боловч эхийн эндэгдлийн түвшин 100000 амьд төрөлтөд 125 промил, нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 21.25 промил байгаа нь эрүүл мэндийн салбарт ажиллах хүчний нөөц бүрдүүлэх, үйлчилгээг сайжруулах, иргэдийн эрүүл мэндээ хамгаалах, үзлэг оношилгоо, эрүүл мэндийн хяналтад хамрагдах сэдэл санаачилгыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байгаа ба цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

2. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг бий болгож, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамралтыг хувийг нэмэгдүүлж 2023 оны зорилтот түвшинд хүрч ажиллах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах

3. 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтад ахуйн осол гэмтлийн шалтгаант нас баралт, болон 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах тал дээр анхаарч “осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг үр дүнд хүргэж, осголт, хөлдөлт, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах

4. Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын жишиг сургууль байгуулах ажлыг эрчимжүүлж тодорхой үр дүнд хүргэх

5. Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутнуудыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, 2023 оны зорилтот түвшинд хүргэх

6. “хүүхдийн хүмүүжил төлөвшлийг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийг үр дүнд хүргэх

7. Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг мөрдөн мөшгөх, мал эмнэлгийн цахим гэрчилгээ олголтыг нэмэгдүүлэх, зорилтот түвшинд хүргэх

8. Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэж, хомсдолоос сэргийлэх зорилгоор сэргээн нутагшуулсан тарваганы тоог өсгөх,

9. Зуунмод хотод уулзалт, үзэсгэлэн худалдаа, арга хэмжээ зохион байгуулах зочид буудал бүхий цогцолбор байгуулах ажлыг эрчимжүүлэх

10. Сэргэлэн суманд 9мвт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, 9мвт хүчин чадалтай цэнэг хураагуурын станц барих төсөл хөтөлбөрийг эрчимжүүлж ажиллах

11. Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн зарим салбар байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажлуудыг эрчимжүүлж, үр дүнд хүргэх

12. Хөрөнгө санхүүгээс шалтгаалж удаашралтай байгаа ажил арга хэмжээг хэрэгжүүлэх талаар бодитой арга хэмжээг авах, дараа онуудын төсөвт тусгуулах тал дээр санал гаргах,

13. Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол болон аймгийн засаг даргын 2022 оны 300 дугаар захирамжаар батлагдсан “бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан нийтлэг болон тусгай шаардлагын дагуу тайлагнах, журмын 6.2 лах хэсэгт заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйгээр үнэлэх

14. Хэлтэс, агентлаг, харьяа байгууллага тайлан ирүүлэхдээ зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн арга хэмжээний үр дүнг бүрэн илэрхийлэхүйц тоо мэдээ, тооцоо судалгаатай, цогц байдлаар тайлагнах

15. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүрэн хангаж үг үсэг, утга найруулгын алдааг хянаж тайлан мэдээг ирүүлэх

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ХУЯГБААТАР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЯРЦЭЦЭГ

